

Аудитаар Хулд, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Адаацаг, Сайнцагаан сумд, Дундговь-Ус, Мандалын гэгээ ОНӨААТҮГ-уудыг хамруулан 18 байгууллагын 126,303.8 сая төгрөгийн хөрөнгөөс 66,605.4 сая төгрөгийн хөрөнгийг 2023 оны 12 дүгээр сарын 31-ны байдлаар түүвэрлэн шалгалаа.

Хүснэгт-13

№	Сумын нэр	Нийт хөрөнгийн дүн	Түүвэртгэсэн хөрөнгийн дүн	Ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийн дүн	Дахин үнэлсэн	Дахин үнэлгээ хийгээгүй хөрөнгийн дүн	Шийдвэртгээгүй	Данснаас хасах шийдвэр гарсан	Акталж устгаагүй	Ашиглалтгүй байгаа
1	Эрдэнэдалай	15,083.2	8,669.0	356.9	5.5	54.1		297.3	11.3	
2	Хулд	7,296.5	3,781.1	203.2	-	48.0	155.2			
3	Адаацаг	8,158.7	508.3	24.4		9.1	15.3			
4	Сайхан-Овоо	12,819.6	9,963.0	22.1	-	22.1				552.6
5	Сайнцагаан	26,091.7	21,459.5	461.6	-	-	-	461.6	-	-
6	Дундговь-Ус ОНӨААТҮГ	39,354.8	21,656.6	57.1	-	-	-	57.1	35.6	
7	Мандалын гэгээ ОНӨААТҮГ	17,499.3	567.9	567.9	131.2	-	-	436.8	10.3	
	Нийт дүн	126,303.8	66,605.4	1,693.2	136.7	133.3	170.5	1,252.8	57.2	552.6

Данснаас хасаж, актлан устгасан хөрөнгийг газар дээр нь үзэж танилцахад 1,693.2 сая төгрөгийн ашиглалтын хугацаа дууссан хөрөнгө байгаагаас 1,252.8 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасах шийдвэр гарсан байна. Данснаас хасах шийдвэр гарсан 57.2 сая төгрөгийн хөрөнгийг актлаж устгаагүй байна. Үүнд:

1. Эрдэнэдалай сумын Ерөнхий боловсролын сургуулийн хуучин гал тогоо;
2. Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын 2,3-р өргөх насосын ажлын байр, Хлор станцын барилга, 3-р гүний худгийн барилга, 3-р гүний худаг, Цэвэрлэх байгууламжийн барилга, Дизелийн барилга;
3. Мандалын гэгээ ОНӨААТҮГ-ын гурвалсан Түргэн үйлчилгээний цэг, 25 ширхэг гэрэлтүүлгийн шонгууд байна.

Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын дизелийн барилгыг данснаас хасаж актлах шийдвэр гарсан хэдий ч хаана байсан, хэзээ буулгасан, хэрхэн шийдвэрлэсэн эсэхийг тус газрын өмч хамгаалах байнгын зөвлөл, удирдлага, нягтлан бодогч нарт ямар нэгэн мэдээлэл байхгүй байлаа. Энэ нь тухай байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эмх цэгц муутай байгааг харуулж байна.

Ашиглалтын хугацаа дууссан боловч байгууллагын хэрэгцээнд ашиглаж байгаа 136.7 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж бүртгэсэн, 133.3 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж бүртгэлд тусгаагүй, цаашид хэрхэн ашиглах талаар шийдвэр гараагүй 170.5 сая төгрөгийн хөрөнгө байна. Тодруулбал:

- Хулд сумын ЗДТГ-т бүртгэлтэй 43.0 сая төгрөгийн, Эрдэнэдалай сумын ЗДТГ-т бүртгэлтэй 44.9 сая төгрөгийн хог зөөврийн машинууд гаалийн бичиг баримтгүй улмаас ашиглалтын хугацаа дууссан ч данснаас хасах боломжгүй болсон;
- Сайхан-Овоо сумын ЗДТГ-т бүртгэлтэй 29.6 сая төгрөгийн хог зөөврийн машин, 25.2 сая төгрөгийн фургон машиныг эвдэрсэн шалтгаанаар АИТХТ-ийн шийдвэргүйгээр сэлбэгийн зориулалтаар ашиглаж байна;
- Хулд сумын ЗДТГ-т бүртгэлтэй бага оврын 2 ширхэг тракторыг нэг бүрийг 50.0 мянган төгрөгөөр үнэлж худалдан борлуулсны орлогыг зохих дансанд тушаагаагүй байсныг аудитын явцад орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Данснаас хасаж, актлах ажлыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс хөрөнгийн бүрэн бүтэн байдал алдагдах, хадгалалт хамгаалалт муудах, үрэгдэн шамшигдах эрсдэлийг бий болгох үр дагавартай байна. Цаашид ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг байгууллагын болон сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт гаргуулан, ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлж бүртгэлд тусгаж, данснаас хасах, актлах хөрөнгийг сумын ИТХ-ын шийдвэрээр ОНӨГ-т саналаа хүргүүлж, АИТХТ-ийн шийдвэр гаргуулж байх шаардлагатай байна. АИТХТ-ийн хөрөнгө данснаас хасах,

акталж устгах шийдвэрийг тогтоолд заасан хугацаанд бүрэн хэрэгжүүлэх ажлыг түргэн шуурхай зохион байгуулж хэвших хэрэгтэй байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгийг акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа сумын өмч хамгаалах байнгын зөвлөлд хүргүүлж, улмаар барилга байгууламж, мотоциклоос бусад тээврийн хэрэгслийн данснаас хасах саналыг аймгийн ИТХТ-ийн 2022 оны 09 дүгээр журмын дагуу ОНӨГ-т хүргүүлснээр АИТХТ-ээр шийдвэр гаргуулан ажиллаж байна. Аудитад хамрагдсан сумд хөрөнгийг акталж устгахдаа сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтын дор хөрөнгийн жагсаалтыг гарган фото зургаар баталгаажуулан устгасан тайланг бичиж баримт үйлдсэн байна.

БҮЛЭГ 2 Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт муу, хөрөнгө үр ашиггүй байна.

Бүлэг 2.1 Дутагдалтай болон илүүдэлтэй хөрөнгийн судалгааг гаргадаггүй, ашиглалтыг сайжруулах арга хэмжээ аваагүй байна.

Дундговь аймгийн хэмжээнд ОНӨГ нь орон нутгийн өмчит хуулийн этгээдээс ашиглалтгүй, дутагдалтай эд хөрөнгийн судалгаа гаргуулан авдаггүй, хэрэгцээ шаардлагыг тодорхойлдоггүй, хяналт шалгалт, дүн шинжилгээ хийдэггүй байна. Харин Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн “Улсын үзлэгийн тооллого”-ыг аймгийн Засаг даргын 2022 оны 4 дүгээр сарын 26 өдрийн А/189 дугаар захирамжийн дагуу удирдан зохион байгуулж, орон нутгийн өмчит 124 төсвийн байгууллага, 2 бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл, 19 ОНӨААТҮГ, 3 сан нийт 148 хуулийн этгээдийг тооллогод хамруулжээ.

“Улсын үзлэгийн тооллого 2022”-ын дүнгээр 9.6 тэрбум төгрөгийн илүүдэлтэй хөрөнгийг илрүүлсэн байна. Аймгийн ИТХ-ын 2022 оны 09 дүгээр тогтоолоор илүүдэлтэй, ашигладаггүй хөрөнгийн шалтгааныг тогтоож, мэдээг орон нутгийн өмчийн бүртгэл, мэдээллийн цахим санд оруулах ажлыг ОНӨГ-т үүрэг болгосон боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна. ТӨБЗГ-т “Улсын үзлэгийн тооллого”-ын хэрэгжилтийг хангуулсан тухай тайлан мэдээг өгч ажиллаагүй, тооллогын мөрөөр авч хэрэгжүүлсэн ажил тодорхойгүй байна.

Улсын үзлэгийн тооллогоор 42 байгууллагын 9.6 тэрбум төгрөгийн балансын үнэтэй 16,404.0 ширхэг илүүдэлтэй, ашиглалтгүй хөрөнгө илэрснийг дараах байдлаар шийдвэрлэжээ.

Хүснэгт-14 /сая төгрөгөөр/

№	Зориулалт	Тоо ширхэг	Үнэлгээ	Шийдвэрлэсэн байдал
1	Газар	2	1.0	шилжүүлэх
		3	2,772.0	шилжүүлэх
2	Барилга	53	3,264.0	актлах
		5	315.0	шилжүүлэх
		3	23.0	дахин ашиглах
		6	191.0	удалдах
3	Биет бус	72	67.0	актлах
		1	0	дахин ашиглах
6	Машин, Тоног төхөөрөмж	1601	1,380.0	актлах
		1	0	худалдах
		8	0	шилжүүлэх
7	Тавилга эд хогшил	3298	195.0	актлах
		1	0	Худалдах
		2	0	дахин ашиглах
		12	21.0	шилжүүлэх
8	Тээврийн хэрэгсэл	16	232.0	Худалдах
		77	643.0	актлах

		5	93.0	шилжүүлэх шилжүүлэх шилжүүлэх
9	Худаг, ус	14	109.0	актлах
		1	25.0	дахин ашиглах
10	Нийтийн эзэмшил	32	109.0	актлах
		2	8.0	худалдах
		2	2.0	шилжүүлэх
	Нийт	5217	9,449.0	

Нэгдсэн тооллогын дүнгээс төсөвт байгууллагуудын өмч хөрөнгийн ашиглалтын байдлыг түүвэрлэн шалгахад 5,768.0 сая төгрөгийн хөрөнгийг актлах, 3,202.0 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэх, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, 431.0 сая төгрөгийн хөрөнгийг худалдан борлуулахаар байна. /актлах, шилжүүлэх, данснаас хасахтай холбоотой хэсгийг бүлэг 1.2-оос үзнэ үү/.

Илүүдэлтэй, ашиглалтгүй байгаа хөрөнгөөс цаашид ашиглах боломжтой 48.0 сая төгрөгийн хөрөнгийн ашиглалтын байдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар хяналт шалгалт хийгээгүй, нэгдсэн тооллогоор өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. 5217 төрлийн 9,449.0 сая төгрөгийн хөрөнгө ашиглалтгүй хадгалагдаж байгаа нь хадгалалтын явцад чанар байдлаа алдах, тоногдож үрэгдэх, хариуцах эзэнгүй болох эрсдэлийг бий болгож байна. Аудитад хамрагдсан Хулд, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Адаацаг сумдын орон нутгийн өмчит газруудын ашиглагдаагүй илүүдэлтэй хөрөнгийг харуулбал:

Хүснэгт-15 /Сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Бүртгэлийн үнэ	Бүртгэсэн он	Тайлбар
Хулд сум					
1	ЗДТГ	Цэвэр усны шугам	35.0	2018	Цаашид ашиглах боломжтой боловч ашиглаагүй.
2	ЗДТГ	Prado-2	20.2	2014	Сумын цагдаа зөвшөөрөлгүй ашиглаж, эвдэлсэн.
		Дүн	55.2		
Сайхан-Овоо сум					
1	ЕБС	Хуучин сургууль	466.2	2018	Шинэ сургууль ашиглалтад орсноор хуучин сургуулийг ашиглаагүй.
3	ЭМТ	Сүрлэн барилга	80.0	2018	ЗДТГ-нь сувилалын зориулалтаар ашиглахаар төлөвлөсөн боловч одоог хүртэл ашиглаагүй
6	ЕБС	ОО-ийн байгууламж	80.0	2021	Хуучин сургуулийн дотор байрладаг
		Дүн	683.8		
Адаацаг сум					
1	ЗДТГ	Шинэ халуун ус	45.4	2018	Анх хүлээж авахдаа шаардлага хангаагүй, муу барилга хүлээж авсан.
2	ЗДТГ	Бохирын машин	25.0	2020	Ашиглаад нэг жил болоод эвдэрсэн
		Дүн	70.4		
Эрдэнэдалай сум					
1	ЗДТГ	Котелийн барилга, тоног төхөөрөмж	46.5	2018	Төвлөрсөн халаалттай болсон

2	ЗДТГ	Ковш	25	2013	Бичиг баримтын зөрчилтэй, ашиглаагүй
3	ЗДТГ	Камер 7 ш	9.9	2022	Засварлаж ашиглах арга хэмжээ аваагүй
4	ЗДТГ	Хог тээврийн машин	44.9	2018	Бичиг баримтын зөрчилтэй, ашиглаагүй
5	ЗДТГ	Ногооны зоорь	10.7	2018	Ашиглаагүй
	Дүн		361.6		

Адаацаг сум 70.4 сая төгрөг, Сайхан-Овоо сум 683.8 сая төгрөг, Хулд сум 359.8 сая төгрөг, Эрдэнэдалай сум 361.6 сая төгрөгийн ашиглалтгүй хөрөнгөтэй байгаагаас дийлэнх хувийг барилга, байгууламж, тээврийн хэрэгсэл эзэлж байна. Мөн төвлөрсөн халаалтад холбогдсон сумдад хуучин уурын зуухны барилга, түүний доторх зуух, бусад тоног төхөөрөмжүүд ашиглагдахгүй байна.

ОНӨГ, сумдын өмч хамгаалах зөвлөл ашиглалтгүй, илүүдэлтэй байгаа хөрөнгийн судалгааг гаргаж дутагдалтай байгууллагад шилжүүлэх, ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд 2021-2023 онд 68-75 тооны хөрөнгийг түрээслүүлж орон нутгийн төсөвт нийт 351.6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. Түрээсийн төлбөрийн үнийг түрээслэгч талын зориулалт, талбайн хэмжээнээс хамаарч журмын дагуу тогтоож, 192.7 сая төгрөг буюу 54.8 хувь нь орон сууцны зориулалтаар, 128.5 сая төгрөг буюу 36.5 хувь нь албан тасалгааны зориулалтаар түрээслсэн байна.

Хүснэгт-16

	Худалдаа, үйлчилгээ	Албан тасалгааны зориулалтаар	Орон сууцны зориулалтаар	Нийт төвлөрүүлсэн дүн	30 хувь төвлөрүүлэхээс	30 хувь төвлөрсөн дүн	Дутуу төвлөрүүлсэн
2021	8.8	34.2	39.0	82.1	24.6	24.6	0.0
2022	10.2	41.6	73.7	125.6	37.7	37.7	0.0
2023	11.2	52.6	79.8	143.8	43.1	40.6	2.4
Нийт	30.4	128.4	192.7	351.6	105.4	103.0	2.4

Аймгийн ИТХТ-ийн 2020 оны 07 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнэ”-ийг баталсан байна.

Уг журмаар орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн орон сууцнаас бусад түрээслүүлж буй байрны түрээсийн төлбөрийн жишиг үнийг 30 хувиар бууруулан түрээслүүлнэ гэж заасан байна. Үүний дагуу Хулд сумын хуучин Соёлын төвийн барилгын 3:4 харьцаатай жижиг өрөөний түрээсийн төлбөрийг бууруулан тогтоосон байна. Бусад хөрөнгийг түрээсийн төлбөрийн жишиг үнээр тогтоож төсөвт төвлөрүүлсэн байна.

Түрээсийн орлогын 30 хувь болох 105.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээс 103.0 сая төгрөгийг төвлөрүүлж, 2.5 сая төгрөгийг 2024 онд төвлөрүүлсэн байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудын түрээсийн гэрээ болон бусад холбогдох баримт материалыг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Хулд сумын ЕБС-ийн хичээлийн байранд үүрэн телефоны /Mobicom, unitel, skytel/ гадна антенныг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 5 жилийн хугацаатайгаар байрлуулахаар гэрээг байгуулсан байна. Түрээсийн төлбөрийг аймгийн ИТХТ-ийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 07 дугаар тогтоолыг үндэслээгүй, 2022 оноос өмнөх 5 жилийн түрээсийн гэрээг байгуулаагүй, түрээсийн төлбөрийг аваагүй, үнэ төлбөргүй ашиглуулсан;
- Хулд сумын ЗДТГ балансад бүртгэлтэй орон сууцны 2 өрөөг иргэнд түрээслүүлэхдээ дээрх тогтоолыг үндэслэлгүй, 100.0 мянган төгрөгөөр түрээслүүлсэн;

- Сайнцагаан, Эрдэнэдалай сумын ЗДТГ балансад бүртгэлтэй худгийг хувь хүмүүст түрээсийн гэрээ байгуулаагүй, үнэ төлбөргүй ашиглуулсан;
- Сайнцагаан сумын ЗДТГ нь төрийн өмчөөс шилжиж ирсэн /Дундговь аймаг дахь Политехникийн коллежийн барилга/ хуучин барилгыг Бизнес хөгжлийн төв, Хот тохижуулах газарт түрээсийн гэрээ байгуулаагүй, үнэ төлбөргүй ашиглуулж байна. Хот тохижуулах газар нь анх түрээслэх үед Сайнцагаан сумын ЗДТГ-ын харьяа байгууллага байсан тул түрээсийн гэрээ байгуулаагүй, түрээс аваагүй. Бизнес хөгжлийн төвийн хувьд бизнес эрхлэгчдийг дэмжин түрээсийн төлбөр авалгүйгээр ашиглалтын зардлыг төлүүлэхээр шийдвэрлэсэн боловч гэрээ, захирамж, шийдвэр огт байхгүй байна. Энэ нь аймгийн ИТХТ-ийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 07 дугаар тогтоолын 1-р хавсралтад заасан түрээсийн төлбөрөөс чөлөөлөгдөж, зөвхөн ашиглалтын зардлаар тооцон төлөх заалтад хамаарахгүй байна. Иймд бизнес эрхлэгчдийг дэмжих ажлын хүрээнд үзүүлж байгаа түрээсийн хөнгөлөлтийн талаар түрээсийн журамд зохих өөрчлөлтийг оруулж, түрээслэгч нартай гэрээ байгуулан, үр дүнг тооцож ажиллах шаардлагатай байна.

Аймгийн ИТХТ-ийн 2020 оны 07 дугаар тогтоолд хөдлөх эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн хэмжээг ашиглалт үйлчилгээнд зарцуулах зардал болон хөдлөх хөрөнгийн эдэлгээний норм, тухайн эд хөрөнгийн ашиглалтын хугацаа, элэгдэл хорогдлын шимтгэл, ашиглалтын нөхцөл, зах зээлийн дундаж үнэ зэргийг харгалзан түрээслүүлэгч өөрөө тогтоож, ОНӨГ-аар баталгаажуулахаар заасан байна. Харин Дундговь-Ус ОНӨААТҮГ нь ААНБ, иргэнтэй байгуулсан машин механизмын түрээсийн гэрээг орон нутгийн өмчийн газраар хянуулж, баталгаажуулаагүй байна.

Цаашид ОНӨГ нь түрээслэх боломжтой, ашиглалтгүй хөрөнгийн судалгааг гаргаж, түрээсийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг судлах, орон нутгийн өмчит байгууллагуудын түрээсийн гэрээнд хяналт тавьж баталгаажуулан, хэрэгжилтийг тооцон ажиллаж байх шаардлагатай байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/39 дүгээр захирамжаар “Тэвшийн говь” ХХК-ийн халаалтын үйл ажиллагааг 2023 оны 02 дугаар сарын 01-ны өдрөөс “Дундговь-Ус” ОНӨААТҮГ-т шилжүүлсэн. “Дундговь-Ус” ОНӨААТҮГ нь 2023 онд дээрх 2 уурын зуухны үйл ажиллагаатай холбоотой 1,200.5 сая төгрөгийн борлуулалтын орлого, 1,641.8 сая төгрөгийн зардал гарч, нийт 441.3 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр тогтоолын хавсралтад “Дундговь-Ус” ОНӨААТҮГ нь 2023 оны 5 дугаар сараас эхлэн 1 метр кубийн халаалтын үнийг төсөвт байгууллага болон ААНБ-д 1,950.0 төгрөгөөр, айл өрхөд 900.0 төгрөгөөр тооцон ажиллаж байна.

Хүснэгт-17

Тэвшийн говь ХХК-ийн 1, 2-р зуухны хэрэглэгчид							
Он	Хэрэглэгчийн төрөл	Хэрэглэгчийн тоо	Талбайн хэмжээ м3	тариф	Орлого /1 сараар/	Зардал /1 сараар/	Алдагдал /1 сараар/
2023	ААНБ-ын	45	53,732.1	1950	104.8		
	Айл өрх	551	20,611.2	900	18.6		
Нийт					123.3	234.5	-111.2
2024	ААНБ-ын	45	78,436.0	1950	153.0		
	Айл өрх	557	20,611.2	900	18.6		
Нийт					171.5	234.5	-63.0

Хүснэгтээс харахад “Дундговь-Ус” ОНӨААТҮГ нь 1, 2-р зуухнаас төсвийн болон ААНБ-ын 45 хэрэглэгч, айл өрхийн 557 хэрэглэгчийг дулаан үйлдвэрлэлээр хангаж, 2023 онд 111.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэ нь тухайн зуухнуудын гол хэрэглэгч болох ГИЦС, Хүмүүнлэг сургууль, 2-р цэцэрлэгийн хуучин барилгуудыг буулгаж шинээр барьж байгаатай холбоотой халаах талбайн хэмжээ буурсан, нүүрс, цахилгаан, тээврийн үнэ өссөн боловч тарифын хэмжээ нэмэгдээгүйтэй тус тус холбоотой байна. Дээрх алдагдалтай холбоотой орон нутгийн

төсвөөс сард 30.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн, мөн 2023 онд нийгмийн хариуцлагын хүрээнд “Биг могул коул энд энерги” ХХК-аас 2000 тн хөөтийн нүүрсийг үнэ төлбөргүй хандивласан байна.

Дээрх төсөвт байгууллагуудын барилгууд 2024 оноос ашиглалтад орж, халаалтын төлбөрөө төлж эхэлснээр сарын орлогын хэмжээ 171.5 сая төгрөг болж, өмнөх оноос 48.2 сая төгрөгөөр нэмэгдэх боловч сар бүр 63.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар байна. Тэвшийн говь” ХХК-ийн халаалтын үйл ажиллагаатай холбоотой төсвийн алдагдлыг бусад үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлж байгаа бөгөөд энэ нь хөрөнгийн үр ашгийг бууруулах, хөрөнгийн шинэчлэл хийх зэрэг боломжуудыг алдах үр дагаврыг бий болгож байна. Иймд “Дундговь-Ус” ОНӨААТҮГ-ын Тэвшийн говь ХХК-аас шилжин ирсэн уурын зуухнуудын ашигт ажиллагааг судалж үзэх шаардлагатай байна.

БҮЛЭГ 2.2 Өмч хамгаалах зөвлөлүүд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, хөрөнгийн хадгалалт хамгаалалт хангалтгүй, дутагдаж гэмтсэн хөрөнгүүдийг хууль журмын дагуу шийдвэрлээгүй байна.


Аймгийн Засаг даргын захирамжаар 2023 оны 6 дугаар сараас ОНӨГ-ын бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орж, 6 орон тоогоор өмчийн бүртгэл, мэдээлэл, ашиглалтад хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж байна. Төрийн албаны зөвлөлийн 691 дүгээр тогтоолоор ОНӨГ-ийн мэргэжилтнүүдийн албан тушаалын тодорхойлолтыг баталжээ.

ТӨБЗ-ын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А-1/2508 дугаар албан бичгээр аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг ОНӨГ-газрын бүтэц, албан тушаалын жишиг жагсаалт болон орон тооны дээд хязгаарыг 12 байхаар хүргүүлжээ. Аймгуудын ОНӨГ-уудын орон тоог тухайн аймгийн орон нутгийн өмчит байгууллагын тоо, нийт хөрөнгөтэй харьцуулан үзлээ.

Хүснэгт-18 /сая төгрөг/

№	Аймгийн нэр	Судалгаагаар					Нэг мэргэжилтэнд ногдох		
		Нийт орон тоо	Мэргэж илтний тоо	ОНӨ-т байгууллагын тоо	ОНӨА АТҮГ	Нийт хөрөнгө	ОНӨ-т байгууллага	ОНӨА АТҮГ	Хөрөнгийн хэмжээ
1	Өвөрхангай	12	6	193	12	287.4	16.1	1.0	24.0
2	Дорнод	12	6	160	17	370.1	13.3	1.4	30.8
3	Дорноговь	13	8	152	7	377.2	11.7	0.5	29.0
4	Сүхбаатар	12	7	140	21	112.1	11.7	1.8	9.3
5	Төв	18	8	225	11	364.5	12.5	0.6	20.3
6	Сэлэнгэ	12	8	283	25	448.6	23.6	2.1	37.4
7	Говь-Алтай	12	9	176	7		14.7	0.6	0.0
8	Баянхонгор	13	9	164	10		12.6	0.8	0.0
9	Баян-Өлгий	15	9	173	3	185.1	11.5	0.2	12.3
10	Увс	12	6	168	4	390.8	14.0	0.3	32.6
11	Дундговь	6	5	143	19	274.5	23.8	3.2	45.8
	Дүн	137	81	1977	136	2810.3			
	Дундаж	12.5	7.4	24.4	1.7	44.6	15.0	1.1	21.9

Харьцуулалтаас харахад Дундговь аймгийн ОНӨГ-ын нэг мэргэжилтэнд ногдох байгууллагын тоо болон хөрөнгийн хэмжээ нь бусад аймгуудаас хамгийн өндөр үзүүлэлтэй байгаа бөгөөд байгууллагын тоо дунджаас 63.0 хувиар, хөрөнгийн хэмжээ дунджаас 47.8 хувиар тус тус илүү байна.



Энэ нь аймгийн ОНӨГ-ын орон тоо бусад аймагтай харьцуулахад бага ба ажилчдын ажлын ачааллыг нэмэгдүүлэх, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт, ажлын хариуцлага сулрах эрсдэлтэй байгааг анхаарч, судалж шийдвэрлэх нь зүйтэй.

Удирдлагууд өмч хамгаалах зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөөг баталдаг ч хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллаагүй байна.

Аймгийн ОНӨГ-т 2023 онд 15 сумын 143 байгууллага өмч хамгаалах зөвлөлийн ажлын төлөвлөгөө, тайланг ирүүлэхээс ажлын төлөвлөгөөг 6 сум, 23 байгууллага, тайланг 19 байгууллага ирүүлжээ. Орон нутгийн өмчит байгууллагуудын 15.2 хувь нь өмч хамгаалах зөвлөлийн ажлын төлөвлөгөө, тайлангаа ирүүлж байгаа нь өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагаа хангалтгүй байна.

Өмч хамгаалах зөвлөлүүдийн төлөвлөсөн ажлын 19.5 хувь нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавихаар төлөвлөсөн ч чиг үүргээ бүрэн хэрэгжүүлдэггүй, зөвхөн актлах хөрөнгийн санал, дүгнэлт гаргах хэмжээнд ажилласан байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудаас Мандалын гэгээ, Дундговь-Ус ОНӨААТҮГ-уудын агуулах нь зориулалтын бус, хөрөнгийг төрөлжүүлээгүй, кодлоогүй, цонх хамгаалалтын торгүй, хаалганы цоожийг лацдаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2000 оны 04 дүгээр сарын 18-ний өдрийн 69 тоот тушаалаар баталсан “Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм”-ийн 14.6-д заасныг зөрчсөн төдийгүй өмч хөрөнгийн чанар байдал алдагдах нөхцөл бий болсон, хөрөнгийн хадгалалт хамгаалалт хангалтгүй байгааг харуулж байна.

ОНӨГ-аас 2023 онд “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам” сэдвээр сургалт хийж Сайнцагаан сумын ЗДТГ, Сургууль, Цэцэрлэгийн 60 ажилтныг хамруулсан байна. Сургалтад хамрагдсан байгууллагуудын ӨХЗ-ийн жилийн ажлын төлөвлөгөө, тайланг шалгахад хангалтгүй байна. Тухайлбал аудитад хамрагдсан сумдын болон орон нутгийн өмчит байгууллагын ӨХЗ-ийн жилийн ажлын төлөвлөгөө, тайланг түүвэрлэн шалгахад:

- Сайнцагаан сумын Цэгцбилэг сургууль, Сайнцагаан сумын ЗДТГ-т ӨХЗ байхгүй¹¹;
- Дундговь-Ус ОНӨААТҮГ өмч хамгаалах зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөө, тайлан байхгүй¹²;
- Сайнцагаан сумын 2, 4, 6-р цэцэрлэгүүдийн ӨХЗ-үүдийн жилийн ажлын төлөвлөгөөнд 16.7-80.0 хувь нь чиг үүрэгтээ хамааралгүй заалтуудыг тусгаж батлуулсан байна.

¹¹ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 06 тоот тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2.2 /...өмч хамгаалах зөвлөлийг ... байгуулна/

¹² аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 06 тоот тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2.5 /... өмч хамгаалах зөвлөл нь ажлын төлөвлөгөөг ... удирдлагаар батлуулж ажиллана./

Гүйцэтгэх удирдлагууд нь ажлын үр дүнг тооцож хариуцлага хүлээлгэх, урамшуулах¹³ зэрэг идэвхжүүлэх арга хэмжээ авдаггүйгээс ӨХЗ-үүд ажлаа төлөвлөдөггүй, төлөвлөсөн нь бүрэн хэрэгжүүлдэггүй, гишүүдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх талаар санаачилж ажилладаггүй байна.

Харин тайлант онд Сайнцагаан сумын ӨХЗ нь жилийн ажлын төлөвлөгөөг сумын Засаг даргаар, хяналт шалгалт хийх удирдамжийг сумын ИТХ-ын даргаар тус тус батлуулж, тооллогын комисс томилуулан 1-р цэцэрлэгт хяналт, шалгалт хийж, сумын Засаг даргын албан бичгээр 4 заалт бүхий зөвлөмж хүргүүлжээ.

Сайнцагаан суманд 2021-2023 онуудад ГИЦС, Хүмүүнлэг сургууль, 2 дугаар цэцэрлэгийн барилга шинээр баригдаж байгаатай холбоотой хуучин барилгуудын буулгалтад сумын ӨХЗ-өөс хяналт тавьж дахин ашиглах боломжтой барилгын материалын үнэ тогтоох, эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгүүлэх, худалдан борлуулж орлогыг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

Цаашид орон нутгийн өмчит байгууллагуудын ӨХЗ-ийн ажилтнуудын мэдлэг, чадварыг дээшлүүлж, ажлын үр дүнг тооцох, хариуцлагын тогтолцоог шат шатанд нь бүрдүүлж, сумдын ӨХЗ-ийн хөрөнгийн хадгалалт хамгаалалтад тавих хяналтыг сайжруулж, арга зүйгээр ханган хамтарч ажиллавал ОНӨГ-ын ажилтнуудын ажлын ачааллыг бууруулах, зөрчилтэй асуудлыг тухай бүр нь хууль журмын дагуу шийдвэрлэж байх боломжтой байна.

Дутагдуулсан, гэмтээсэн буруутай этгээдээр нөхөн төлүүлж, хохиролгүй болгох, хариуцлага тооцох арга хэмжээ аваагүйгээс хөрөнгө эзэнгүйдсэн байна.

Орон нутгийн өмчит 143 хуулийн этгээдийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулах тооллогын комиссыг аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/189 дүгээр захирамжаар 10 хүний бүрэлдэхүүнтэй томилон дүн, мэдээ, тайланг нэгтгэж, тайлагнажээ. Тус тооллогоор анх дутуу хүлээж авсан, ашиглалтын явцад хулгайд алдсан, шамшигдуулсан зэрэг шалтгаанаар нийт 9 байгууллагад хамааралтай нийт 48.0 сая төгрөгийн 22 ширхэг хөрөнгө дутагдсан дүн гарчээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2022 оны улсын үзлэг тооллогын дүн баталгаажуулах тухай аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 91 дүгээр тогтоол гарч эд хөрөнгийн маргаантай, дутагдуулсан байгууллагыг шалгаж буруутай этгээдээр нөхөн төлүүлэх ажлыг зохион байгуулахыг Санхүүгийн хяналт, аудитын албанд үүрэг болгосон байна.

Үүний дагуу улсын үзлэг шалгалтаар дутагдсан өмч хөрөнгөд шалгалт хийх удирдамжийг боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд хяналт шалгалт хийжээ. Тус хяналтаар дараах шийдвэрүүдийг гаргасан байна. Үүнд:

1. Зөрчлийг арилгуулах 0.5 сая төгрөгийн албан шаардлага /1 нэр төрлийн хөрөнгө/ ;
2. Зөрчлийг арилгуулах 47.5 сая төгрөгийн зөвлөмж /12 нэр төрлийн хөрөнгө/ хүргүүлжээ.

Санхүүгийн хяналт, аудитын албаны хяналт шалгалтаас өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 77.3 хувьтай байна.

Албан шаардлага, зөвлөмжөөс:

- Шийдвэргүйгээр буулгасан 5.9 сая төгрөгийн бүртгэлийн үнэтэй Хулд сумын Эрүүл мэндийн төвийн гражийн барилга,
- Унагаж эвдэлсэн 20.2 сая төгрөгийн бүртгэлийн үнэтэй Хулд сумын ЗДТГ-ын Toyota Land Cruiser Prado автомашин өнөөг хүртэл шийдвэрлэгдээгүй байна.

¹³ “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 4.1 /Өмч хамгаалах зөвлөл нь ... хариуцлага хүлээгч/, 4.2 /... өмч хамгаалах зөвлөлийн ажлын үр дүнгээс хамааруулан холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн урамшуулал олгоно/

Эдгээр нь орон нутгийн өмчит байгууллагын удирдлагууд өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулдаггүй, зөрчил гаргасан этгээдтэй хариуцлага тооцох асуудлыг тухай бүр шийдвэрлэх ажлыг зохион байгуулах чиг үүргээ бүрэн хэрэгжүүлдэггүйтэй холбоотой байна.

Орон нутгийн өмчит байгууллагуудын удирдлага, холбогдох албан тушаалтнууд болон сумдын ӨХЗ чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хяналтгүй болж эзэнгүйдэх, үрэгдэх нөхцөл бүрдсэн, өмч хөрөнгийн харилцаатай холбоотой зөрчлүүд буураагүй байна.

Аудитад хамрагдсан сум байгууллагуудын хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг түүвэрлэн үзэхэд 580.9 сая төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүснэгт-19

№	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Бүртгэлийн үнэ	Бүртгэсэн он	тайлбар
1	Хулд сумын ЗДТГ	Ланд Cruiser 100 автомашин	49.5	2019	5 бул нь эвдэрсэн
2		Prado-2	20.2	2014	унагасан
3	Хулд сумын ЕБС	50 хүүхдийн дотуур байр	146.3	1958	тоногдсон
4	Сайхан-Овоо сумын ЗДТГ	Фермер УАЗ	20.0	2012	тос масло нь холилдсон /4 жил айлын хашаанд байсан/
5		Наадмын талбайн	41.9	2009	дээвэр хуурсан.
6		Land Cruiser prado	125.0	2020	Унагасан /УБ хотод байгаа/
7		УАЗ-2201 автомашин	25.2	2015	эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр задалж сэлбэгт ашигласан.
8		өөрөө буулгагч хогийн машин	29.6	2021	
9	Адаацаг сумын ЭМТ	УАЗ 369 маркийн автомашин			шийдвэргүйгээр ЗДТГ-т шилжүүлж ашиглуулсан, 2023 онд дуудлага худалдаагаар 3.5 сая төгрөгөөр зарагдсан боловч дуудлага худалдаанд танилцуулсан зургаас өөр байсан тул худалдаж авсан иргэн мөнгөө буцаан нэхэмжилсэн
10	Адаацаг сумын ЗДТГ	Nissan mirino 20-66 ДУЭ маркийн автомашин	10.0		тоногдсон байдалтай Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын хашаанд хадгалалт, хамгаалалтгүй байна
11	Мандалын гэгээ ОНӨААТҮГ	нийтийн эзэмшлийн тоглоомын талбайн	25.6		9 байршилд байгаа тоглоомын талбайн 7 нь эвдрэлтэй.
Эвдэрч гэмтсэн хөрөнгийн дүн			493.3		
12	Хулд сумын ЗДТГ	бэлчээрийн хашаа	20.0	2014	Дутагдсан.
13	Мандалын гэгээ ОНӨААТҮГ	аймгийн угтах хаалганы /20ш/ гэрэлтүүлэг, нарны панель	11.0		Дутагдсан.
14		3 ширхэг сайжруулсан ариун цэврийн байгууламж	7.5		Дутагдсан.
15		9 ширхэг хогийн сав	5.9		Дутагдсан.

	Гэрэлтүүлэг-17 ширхэг /Залуус хороолол, 4-р сургууль, 5-р баг/	43.2	Дутагдсан.
Дутагдсан хөрөнгийн дүн		87.6	

Дээрх зөрчлүүдээс эвдэрч гэмтсэн, дутагдсан өмч хөрөнгийн эзэн холбогдогч, шалтгаан, хохирлын хэмжээг тогтоогоогүй, хохирлыг барагдуулах арга хэмжээ аваагүйгээс гадна өмч хөрөнгийг шийдвэргүйгээр бусдад дамжуулах, үрэгдүүлэх ноцтой зөрчил дахин давтан гарсан, хариуцлага тооцолгүй хугацаа алдаж эзэнгүйдүүлэн акталж данснаас хасах тохиолдол гарсаар байгааг анхаарч ажиллах шаардлагатай болсон байна.

Цаашид эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр хөрөнгийг бусдад шилжүүлдэг зөрчлийг таслан зогсоох, эвдрэл гэмтлийн шалтгааныг тухай бүр тогтоож холбогдох мэргэжлийн байгууллагын акт дүгнэлтээр баримтжуулах, дутагдал гэмтлээс гарсан хохирлыг гэм буруутай хүмүүсээр нөхөн төлүүлэх, хуулийн байгууллагад шилжүүлэх зэргээр тооллого тооцооны үр дүнг тухай бүрд нь хууль журмын дагуу шийдвэрлэж байх нь зүйтэй.

Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулдаг ч үүргийн биелэлтийг тооцдоггүйгээс үр дүнгүй болсон байна.

Аудитад хамрагдсан байгууллагууд эд хариуцагч нартай эд хөрөнгийн хариуцлагын гэрээ байгуулсан боловч зарим гэрээний хугацаа тодорхойгүй, гэрээний үүргийн биелэлтийг дүгнэж ажиллаагүйгээс ач холбогдолгүй болсон байна. Энэ нь эд хөрөнгийн хариуцлагын гэрээнд тухайн гэрээг хэн, хэзээ дүгнэж үр дүнг хэнд тайлагнах талаар заалт оруулаагүйгээс шалтгаалсан бөгөөд эд хөрөнгийн харилцаатай холбоотой зөрчил маргаан үүссэн тохиолдолд шийдвэрлэх, хариуцлага тооцох боломжгүй болох үр дагавартай байна.

Цаашид эд хөрөнгийн хариуцлагын гэрээнд тухайн гэрээний үүргийн биелэлтийг хэзээ хэн дүгнэж үр дүнг хэнд тайлагнах талаар заалт оруулах, гэрээний үүргийн биелэлтийг дүгнэж, холбогдох албан тушаалтанд танилцуулж хэвших нь зүйтэй.

Нийтийн эзэмшлийн үрэгдэж дутагдсан хөрөнгийг “гэм буруутай этгээдийг олох боломжгүй” гэсэн шалтгаанаар акталж данснаас хасах санал гаргасан нь хууль тогтоомж зөрчсөн байна.

ОНӨГ-аас ирүүлсэн судалгаагаар 2020-2023 онуудад аймгийн хэмжээнд нийт 9,238.5 сая төгрөгийн хөрөнгийг нийтийн эзэмшлийн өмч хөрөнгөнд бүртгэсэн байна. Үүнийг хөрөнгийн төрлөөр ангилбал 1,295.4 сая төгрөг буюу 14.0 хувийг гэрэлтүүлэг, 1,034.0 мянган төгрөг буюу 11.2 хувийг зам зогсоол, 924.8 сая төгрөг буюу 10.0 хувийг тоглоомын талбай эзэлж байгаа бол 92.8 сая буюу 1.0 хувийг мод ургамал, 5,891,5 буюу 63.8 хувийг бусад хөрөнгө тус тус эзэлж байна.

График-9

Харин хөрөнгийн эзэмшлээр нь үзвэл Мандалын гэгээ ОНӨААТҮГ 5,088.1 сая буюу 55.1 хувийг, Дундговь-Ус ОНӨААТҮГ 452.9 сая төгрөг буюу 4.9 хувийг тус тус эзэлж байгаа нь хамгийн их үзүүлэлттэй байна.

Мандалын гэгээ ОНӨААТҮГ-ын хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийтийн эзэмшлийн өмч хөрөнгөөс:

Огт ургаагүй 3.7 сая төгрөгийн бүртгэлийн үнэтэй 2020 онд орлогод авсан 2,590 ширхэг сухай, барилга, гудамж, хашааны хаягжуулалтад зарцуулсан 8.5 сая төгрөгийн бүртгэлийн үнэтэй 490 ширхэг тэмдгийг хөрөнгийн дансанд үлдэгдлээр тайлагнасан байна. Энэ нь байгууллагын нягтлан бодогч эд хөрөнгийн тооллого, тооцоог хийн үлдэгдлийг тулган шалгаж, баталгаажуулаагүй, бүртгэлээ аккрузл сууриар үнэн зөв хөтлөөгүйгээс шалтгаалсан тул НББ-д залруулах нь зүйтэй.



Мандалын гэгээ ОНӨААТҮГ-ын ӨХЗ-ийн 2024 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хурлаар нийтийн эзэмшлийн өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтад хийсэн төлөвлөгөөт хяналтын дүнг хэлэлцсэн байна. Тус хурлын тэмдэглэлд 2023 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор бүрэн байсан боловч төлөвлөгөөт хяналтаар дутагдсан хөрөнгийг тухайн орчинд камер байхгүйгээс эзэн холбогдогчийг олох боломжгүй тул акталж данснаас хасуулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлэхээр шийдвэрлэлээ гэжээ.

ӨХЗ-ийн хурлаар үрэгдэж дутагдсан хөрөнгийг акталж данснаас хасахаар шийдвэрлэж байгаа нь дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг гэм буруутай хүмүүсээр төлүүлэх, хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдүүлэх чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Аудитын явцад тодруулахад нийтийн эзэмшлийн хөрөнгө хэзээ үрэгдэж дутсан нь тодорхойгүй мөн эвдэрч гэмтсэн хохирлын дүнг тогтоох боломжгүй байлаа. Иймд Мандалын гэгээ ОНӨААТҮГ-ын санхүүгийн бүртгэлийн программд багц хөрөнгийг иж бүрдлээр нь задлалгүй нийт дүнгээр нь бүртгэсэн байсныг аудитын явцад хөрөнгийн иж бүрдлээр үнэлүүлэн тооцуулж, зөвлөмж өгч ажиллалаа. Тухайлбал: Хорооллуудын дунд 5 байршилд байгаа 12 иж бүрдэл бүхий жишиг хүүхдийн тоглоом, амралт чөлөөт цаг өнгөрөөх талбайг нийт 473.6 сая төгрөгийн 1 ширхэг хөрөнгөөр бүртгэлд тусгасан байна. Энэ нь хөрөнгийн иж бүрдлээс хэсэгчлэн акталж данснаас хасах, хохирлыг үнэлж нөхөн төлүүлэх зэргээр хөрөнгийн хөдөлгөөнийг бүртгэх, санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнах боломжгүй болгосон байна.

Цаашид Мандалын гэгээ ОНӨААТҮГ-ын хөрөнгийн бүртгэлийг холбогдох стандартын дагуу хөтлөх, нийтийн эзэмшлийн эвдэрч гэмтсэн хөрөнгийг эзэн холбогдогчийг тогтоох боломжгүй шалтгаанаар акталж данснаас хасах зөрчлийг давтан гаргахгүй байх, хохирлыг журмын дагуу хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх, нийт хөрөнгийн хадгалалт хамгаалалт, түүнд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Аймгийн ОНӨГ-т ирүүлсэн 6 сум, 23 байгууллагын 2023 оны жилд гүйцэтгэхээр төлөвлөсөн нийт 123 заалт ажлаас зөвхөн Дэрэн сумын Ерөнхий боловсролын сургууль “1-9 дүгээр ангийн сурагчдад эд хөрөнгийг зөв ашиглах хамгаалах талаар сургалт зохион байгуулах”-аар төлөвлөсөн байна. Энэ нь нийт ажлын 0.8 хувийг эзэлж байгаа бөгөөд бусад байгууллагуудад нийтийн өмч хөрөнгийг хамгаалах хүмүүжлийг хүүхэд залуучуудад төлөвшүүлэх талаар санаачлан хэрэгжүүлсэн ажил байхгүй байна. Өмч хөрөнгөтэй зөв зохистой харьцах хүмүүжлийг хүүхэд залуучуудад төлөвшүүлэх нь нийтийн эзэмшлийн өмч хөрөнгийн ашиглалтын хугацааг уртасгах, хадгалалт

хамгаалалтыг сайжруулах төдийгүй соёл хүмүүжлийн өндөр ач холбогдолтой, чиг үүрэг бүхий байгууллагаар хязгаарлахгүй бүх нийтийг хамруулбал үр дүн гарах боломжтой байна.

Иймд холбогдох байгууллагууд нийтийн өмч хөрөнгийг хамгаалах, ариг гамтай хэрэглэх соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах, иргэд олон нийтийг оролцуулах, уриалга гаргах, ЕБС, СӨБ-ын байгууллагуудтай хамтран сургалт сурталчилгаа хийх зэрэг ажлыг тогтмол хийж хэвших шаардлагатай байна.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн эрэлт хэрэгцээний судалгааг гаргаж, нэгтгэн эрэмбэлдэггүй, хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлтөд ОНӨГ-ын оролцоог хангадаггүй нь төсөв хөрөнгийн хуваарилалт оновчтой бус, илүүдэлтэй, дутагдалтай хөрөнгө бий болох шалтгаан болж байна.
2. Орон нутгийн өмчид шинээр тээврийн хэрэгсэл авахдаа ОНӨГ-аас зөвшөөрөл авдаггүй, салбарын онцлог, хэрэгцээ шаардлагад үндэслэн автомашины төрөл, туулах чадварыг харгалзан үзэж оновчтой хуваарилахгүй байна.
3. Орон нутгийн өмчийн хөрөнгийг актлах, данснаас хасах үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулсан ч хөрөнгийн доод үнийг тогтоох шалгуур үзүүлэлт байхгүй, дуудлагын худалдаагаар худалдах үндсэн хөрөнгийн санал болгох доод үнийг дээд газраас баталсан журамд нийцүүлэн батлаагүй байна.
4. Орон нутгийн өмчийн газар нь аймгийн ИТХ-ын тогтоолоор орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасагдсан, акталсан хөрөнгийг Санхүү, төрийн сангийн хэлтэс, аймгийн ерөнхий нягтлан бодогчтой тооцоо нийлж баталгаажуулдаггүй байна.
5. Аймгийн ИТХ-ын шийдвэр гарсан өдрөөс 14 хоногийн дотор зарлах хугацаанаас 5 нэр төрлийн хөрөнгийн зарыг 11-273 хоногийн хугацаа хэтрүүлэн зарласнаар хөрөнгийн хадгалалт, хамгаалалт муудаж, үрэгдэн шамшигдах нөхцөл бий болж, тухайн хөрөнгийн үнэ цэнийг бууруулж байна.
6. Орон нутгийн өмчит байгууллагуудын удирдлага, өмч хамгаалах зөвлөлийн мэдлэг, мэдээлэлгүй байдлаас ашиглалтын хугацаа дууссан хөрөнгүүдийг хэрхэн шийдвэрлэх талаар арга хэмжээ авдаггүй, акталж устгах шийдвэр гарсан хөрөнгийг устгал үйлдэж, дүгнэлт гаргаж ажиллахгүй байна.
7. Дутагдалтай болон илүүдэлтэй хөрөнгийн судалгааг гаргаж, илүүдэлтэй хөрөнгийг дутагдалтай байгууллагад шилжүүлэх, ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авдаггүй, хөрөнгийн ашиглалт, үр ашигт байдалд хяналт хийж, үр дүнг тооцон ажиллахгүй байна.
8. ОНӨГ-ын орон тоо харьцангуй бага, батлагдсан орон тоо дутуу ажиллаж байгаа нь өмч хөрөнгийн бүртгэл мэдээлэл, ашиглалт, хадгалалт хамгаалалтад тавих хяналт хангалтгүй байхад нөлөөлж байна.
9. Сумдын болон орон нутгийн өмчит байгууллагуудын удирдлагууд эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээний үүргийн биелэлтийг дүгнэдэггүй, ӨХЗ-ийн ажлын үр дүнг тооцдоггүйгээс өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хяналтгүй болсон, хөрөнгө дутагдуулсан, гэмтээсэн буруутай этгээдээр нөхөн төлүүлж, хохиролгүй болгох, хариуцлага тооцох арга хэмжээ аваагүйгээс зөрчил арилаагүй дахин давтан гарсан байна.

10. Нийтийн эзэмшлийн өмч хөрөнгийн бүртгэл алдаа зөрчилтэй, хадгалалт хамгаалалт хангалтгүй, дутагдсан, эвдэрч гэмтсэн хөрөнгийн эзэн холбогдогчийг олж тогтоох, хариуцлага тооцох арга хэмжээ аваагүй, өмч хөрөнгийг зөв зохистой ашиглах хүмүүжлийг иргэд олон нийт, хүүхэд залуучуудад төлөвшүүлэх ажил хийгээгүй байна.



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн эрэлт хэрэгцээний судалгааг гаргаж, нэгтгэн эрэмбэлэн, санал дүгнэлт боловсруулж ХОХБТХ-т хүргүүлэн, хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлтөд тусган шийдвэрлүүлж байх;
2. Орон нутгийн өмчид шинээр тээврийн хэрэгсэл авах бүрт салбарын онцлог, хэрэгцээ шаардлагад үндэслэн автомашины төрөл, туулах чадвар, ашиглаж байгаа тээврийн хэрэгслийн ашиглалтын байдлыг харгалзан үзэж ОНӨГ-аас зөвшөөрлийг гаргуулан, шийдвэрлүүлж байх;
3. “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” журамд данснаас хасах, дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийн үнэ тогтоох шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тусгах, дуудлага худалдаагаар худалдах, дуудлага худалдаа зохион байгуулах /Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 38-45 дугаар зүйл баримтална/ талаарх заалтыг оруулж шинэчлэн батлуулах;
4. Дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийг АИТХТ-ын 2017 оны 51 дүгээр тогтоолд заасан хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан маягтын дагуу нийтэд зарлан мэдээлж, хөрөнгийн үнэ цэнийг бууруулахгүй байх;
5. Дуудлагын худалдаагаар худалдах үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэх тухай журамд тусгаж, хэрэгжүүлэн ажиллах;
6. Ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг байгууллагын болон сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт гаргуулах, ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлж бүртгэлд тусгах, данснаас хасах, актлах хөрөнгийг сумын ИТХ-ын шийдвэрээр Орон нутгийн өмчийн газарт саналаа хүргүүлж АИТХТ-ийн шийдвэр гаргуулж байх;
7. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А-1/1819 тоот зөвлөмж, бусад аймгуудын ОНӨГ-ын мэргэжилтнүүдийн ажлын ачаалал зэргийг үндэслэн ОНӨГ-ийн орон тоо нэмэгдүүлэх боломжийг судалж шийдвэрлэх;

Орон нутгийн өмчийн газарт:

1. ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан гарах бүрд хөрөнгийн үлдэгдэл, хөдөлгөөнтэй холбоотой тоон мэдээллийг Санхүү, төрийн сангийн хэлтэстэй тооцоо нийлж баталгаажуулж байх;
2. Улсын тооллогоор болон аудитаар дутагдсан 87.6 сая, эвдэрч гэмтсэн 401.9 сая, нийт 489.5 сая төгрөгийн өмч хөрөнгө, авто тээврийн хэрэгслийн эзэн холбогдогч, шалтгааныг тогтоож, гэм буруутай этгээдээр хохирлыг барагдуулах арга хэмжээ авах талаар хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх;

3. ӨХЗ-ийн ажлыг тухайн албан хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд оруулан үр дүнг тооцож хэвших, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтад хяналт тавих ажлыг орон нутгийн өмчит байгууллага, сумдын удирдлага, ИТХ, бусад холбогдох хяналтын байгууллагуудын хүрээнд зохион байгуулж, хяналтыг бүх шатанд сайжруулах;
4. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 зүйлийн 11.5-т *“орон нутгийн өмчийг удирдах ажилд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх”* заасны дагуу Төрийн бодлого, зохицуулалтын газраас Сангийн сайдын 2016 оны 131 дүгээр тушаалын 6.3-т заасан шалгуур үзүүлэлтээр дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн доод үнийг тогтоох аргачлалыг шинэчлэн боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах;
5. ОНӨГ-ын хөрөнгийн бүртгэлийн системийг хөрөнгийн орлого, зарлага, үлдэгдлийн мэдээллийг хөрөнгийн данс, эх үүсвэр, салбар, нутаг дэвсгэрийн байршил зэргээр нэгтгэн гаргаж, харьцуулсан судалгаа, дүн шинжилгээ хийж болохуйц байдлаар сайжруулалт хийх саналыг ТӨБЗГ-т хүргүүлэх.